*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*2 дугаар хавсралт*

# ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.БААТАРСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Стратегийн төлөвлөгөөний зорилго 1. “Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ.” | | | | | | | |
| Зорилт 1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангах, тайлагнах | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ: 1.1 Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, сургалт арга зүйгээр хангахад чиглэсэн арга хэмжээ авах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 91.1% (5 бүлгийн 89 арга хэмжээг төлөвлөж 91.1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.) | 50% | 100% | 01 | 12 |
| 2 | Арга хэмжээ: 1.2 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудыг идэвхжүүлэх, татан оролцуулах болзолт аян, уралдааныг зохион байгуулж, хяналт тавих | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | “Манай хороо – Миний гудамж” аяныг зохион байгуулсан. | 1 | 1 | 04 | 10 |
| 3 | Арга хэмжээ: 1.3 Мод тарих, арчлах хамгаалах талаар мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 3 удаагийн сургалт, 10 цахим сурталчилгаа, | 5-аас багагүй | 10-аас багагүй | 03 | 10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | онол, практикт суурилсан сургалт нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулна. | | 1050 гарын авлагыг бэлтгэж, түгээсэн. | | | | |
| 4 | Тохижилт, бүтээн байгуулалтын жил, Ойн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах, тайлагнах | Батлагдсан төлөвлөгөө, тоо | - | 2 | - | 01 | 03 |
| | | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | - | 30% | 90%-иас багагүй | 01 | 12 |
| Зорилт 2. Дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт, ногоон байгууламжийг хөгжүүлэх бодлого боловсруулж төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах. | | | | | | | |
| 5 | Арга хэмжээ: 2.1 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд тохижилт, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, тоглоомын талбай, спорт талбайг нэмэгдүүлж, ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээний ажилд хотын стандартын хэм хэмжээ, шаардлагыг хангуулж, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнаж ажиллана. | Шинээр нэмэгдүүлсэн цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгийн тоо | 18 (2021-2023 он) | 1 | 4 | 04 | 12 |
| | | Шинээр нэмэгдүүлсэн тоглоомын талбай, тохижилтын тоо | 64 (2021-2023 он) | 2-оос багагүй | 10-аас доошгүй | 04 | 12 |
| | | Ашиглалтад оруулсан спорт талбайн тоо | 22 (2021-2023 он) | 2-оос багагүй | 9 спорт талбай шинээр байгуулж, 1 спорт заалыг засварлана. | 04 | 12 |
| | | Засварлаж, шинэчилсэн талбай, эд хөрөнгийн тоо | 4 байршилд цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, 1 хөшөөг засварлаж шинэчилсэн. | 1-ээс багагүй | 4-ээс доошгүй | 04 | 12 |
| 6 | Арга хэмжээ: 2.2 Явган хүний зам болон дугуйн зам шинээр нэмэгдүүлэх ажлын явц, | Явган хүний замын урт, км | 4.9 (2023 он) | 1.0-ээс багагүй | 1.5-аас багагүй | 04 | 12 |
| | | Дугуйн замын урт, км | - | 0.3-аас багагүй | 0.6-аас доошгүй | 04 | 12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлд хяналт тавих, шинээр нэмэгдүүлэх, засварлаж, шинэчлэх судалгааг боловсруулах | Боловсруулсан судалгаа | 1 | 1 | - | 04 | 12 |
| 7 | Арга хэмжээ: 2.3 “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдөр арга хэмжээг зохион байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, хяналт тавих | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 2 | 1 (хавар) | 1 (намар) | 05 | 11 |
| | | Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ, м.кв | 9.32 (2023 оны жилийн эцсийн байдлаар) | - | 9.5 | 05 | 11 |
| | | Арчлалт хамгаалалт хийх талбай, м.кв | - | 289,376 | 289,376 | 01 | 12 |
| 8 | Арга хэмжээ: 2.4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Айцын аманд байгуулсан ойжуулалтын талбай, Төгсөгчдийн төглийн арчлалт хамгаалалтыг тогтмол гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллана. | Арчлалт хамгаалалт хийх талбай, га | 8 | 13.5 | 13.5 | 01 | 12 |
| 9 | Арга хэмжээ: 2.5 Ногоон байгууламжийн судалгаа хийж, газарзүйн мэдээллийн санд суурилсан мэдээллийн сан үүсгэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж, батлуулах, ажлын явц гүйцэтгэлд хяналт тавих | Батлуулсан ажлын даалгавар, тоо | - | 1 | 1 | 01 | 02 |
| | | Ногоон байгууламжийн судалгаа, мэдээллийн сан хийх ажлын явц, хувь | 10% | 30% | 100% | 02 | 12 |
| 10 | Арга хэмжээ: 2.6 Гоёл чимэглэлийн цэцгийн үрсэлгээг хийх, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд цэцгийн мандал байгуулах | Үрслүүлсэн цэцэг, тоо | 267,519 | 300,000-аас багагүй | - | 02 | 06 |
| | | Мандал байгуулсан талбай, м.кв | 5379,3 м.кв (2023 он) | Талбайн цэвэрлэгээ, хөрс | 3000 м.кв-аас багагүй | 06 | 10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулж, явц, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах | | | боловсруулалтыг хийнэ. | | | |
| 11 | Арга хэмжээ: 2.7<br>Сул шороон хөрсийг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгон тоосжилтыг бууруулах ажлын хүрээнд холбогдох судалгаа, тооцооллыг боловсруулж, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлд хяналт тавих | Зүлэгжүүлсэн талбай, м.кв | 24192.8 м.кв | 15,000 м.кв-аас багагүй | Усалгаа, арчлалт хамгаалалтыг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллана. | 06 | 08 |
| 12 | Арга хэмжээ: 2.8<br>Гэр хорооллын айл өрхүүдтэй хамтарч мод, бут тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх судалгаа, тооцооллыг боловсруулж, хэрэгжүүлэх, хяналт тавих | Шинээр тарьсан мод, бутны тоо | 18,450 ширхэг (2023 онд 6, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны 1895 хашаанд тарьсан) | 10,500 | 15,000 | 05 | 11 |
| Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 13 | Арга хэмжээ: 3.1<br>Төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан мөрдөж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | 100 | 01 | 12 |
| 14 | Арга хэмжээ: 3.2<br>Албан бичиг хэргийг хөтлөх, байгууллага иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг судалж, түргэн шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана. | Шийдвэрлэлт, хувь | 100 | 100 | 100 | 01 | 12 |
| 15 | Арга хэмжээ: 3.3<br>Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг боловсруулах, зохион | Шийдвэрлэлт, хувь | 100 | 100 | 100 | 01 | 12 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах MNS5140:2011 стандартыг мөрдөх | | | | | |
| 16 | Арга хэмжээ: 3.4<br>Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн хэрэг бүрдүүлэх, албан хэрэг хөтлөгдөх хугацаа дуусмагц, зохих зааврын дагуу цэгцэлж, бүрэн бүрдэлтэйгээр баримт бичиг хүлээн авах хуваарийн дагуу байгууллагын архивт шилжүүлэх | Шийдвэрлэлт, хувь | 100 | 100 | 100 | 01 | 12 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 17 | Арга хэмжээ 1.<br>Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнийг дагалдан гарсан дүрэм, журмын сургалтад хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | - | 1 | - | 03 | 10 |
| 18 | Арга хэмжээ 2.<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалтад хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | - | 1 | - | 03 | 10 |
| 19 | Арга хэмжээ 3.<br>Ажил үүргийн чиг үүрэгтэй холбоотой нийслэл, дүүрэг | Хамрагдсан сургалтын тоо | 10 | 2-оос багагүй | 4-ээс багагүй | 03 | 10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон бусад газруудаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх | | | | | | |

**ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.БААТАРСҮРЭН 2024.01.08
огноо

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.ТУЯАЦЭЦЭГ 2024.01.08
огноо

106

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.БААТАРСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Стратегийн төлөвлөгөөний зорилго 1. "Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ. | | | | | | | |
| Зорилт 1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангах, тайлагнах | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ: 1.1 Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, сургалт арга зүйгээр хангахад чиглэсэн арга хэмжээ авах 2024.01 – 2024.12 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 91.1% (5 бүлгийн 89 арга хэмжээг төлөвлөж 91.1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.) | 100% | Тохижилт бүтээн байгуулалтын жил болгон зарласантай холбогдуулан хотын стандартыг хэрэгжүүлэх, төлөвлөгөөнд тусгах санал солилцох уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 26-нд зохион байгуулж, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:<br>1. Хот, нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжсэнээр гэрэлтүүлгийн урсгал, засвар ашиглалт хариуцсан 3, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг хариуцсан 10 байгууллагын ажил, үйлчилгээнд холбогдох стандарт, норм дүрмийг мөрдүүлж, хяналт тавьж ажилласан.<br>2. Хотын стандарт, хяналтын газрын Байгаль орчны стандартын хэлтэстэй хамтран ажиллах | 2024.01.02 2024.11.29 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөний хүрээнд хог хаягдлын менежмент, ногоон байгууламжийн бүлгийн стандартыг танилцуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 75 сууц өмчлөгчдийн холбоо, 10 ногоон байгууламжийн арчилгаа хариуцсан компанийн 90 ажилтан, албан хаагчдыг хамруулсан. | | |
| 2. | Арга хэмжээ: 1.2 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудыг идэвхжүүлэх, татан оролцуулах болзолт аян, уралдааныг зохион байгуулж, хяналт тавих 2024.04 – 2024.10 | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | “Манай хороо – Миний гудамж” аяныг зохион байгуулсан. | 1 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/67 дугаар захирамжийг батлуулж, хороод, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлсэн.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн 190 аж ахуйн нэгжид гадна тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулах, гэрэлтүүлэг, хаягийн байгууламжийг сайжруулах талаар үүрэг чиглэл өгч, хаягийн байгууламжийг шинэчлэх шаардлагатай 5 аж ахуйн нэгжийн хаягийн байгууламжийг стандартад нийцүүлэн солиулж, 3 аж ахуйн нэгж, гадна талбайг бүрэн тохижуулсан.<br>Ногоон хот – Иргэний оролцоо мод тарих аяныг зохион байгуулж, хавар 1650 өрх, 104 сууц өмчлөгчдийн холбоо, 23 цэцэрлэг, 16 ерөнхий боловсролын сургууль, аж ахуйн нэгж байгууллагууд нэгдэж, 206419 ширхэг мод, бут сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. | 2024.02.05<br>2024.10.26 | 100 |
| 3. | Арга хэмжээ: 1.3 Мод тарих, арчлах хамгаалах талаар мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр онол, практикт | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 3 удаагийн сургалт, 10 цахим сурталчилгаа, 1050 гарын авлагыг | 10-аас багагүй | Мод, цэцэг тарьж, арчлах чиглэлээр 5, хотын стандартыг танилцуулах, хэрэгжүүлэх чиглэлээр 2 удаагийн сургалт, 1 нөлөөллийн аян, 4 удаагийн зөвлөмж, уриалгыг бэлтгэж, дүүрэг | 2024.03.01<br>2024.10.31 | 100 |

168

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | суурилсан сургалт нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулна. 2024.03 – 2024.10 | | бэлтгэж, түгээсэн. | | хорооны цахим хуудсаар сурталчилсан. Үүнд: Хотын стандарт хяналтын газартай хамтран ногоон байгууламжийн бүлгийн стандартыг танилцуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 75 сууц өмчлөгчдийн холбоо, 10 ногоон байгууламжийн арчилгаа хариуцсан компанийн 90 ажилтан, албан хаагчдыг хамруулсан. Ногоон хот – Иргэний оролцоо мод тарих аяны хүрээнд дүүргийн ерөнхий боловсролын 63 сургууль, цэцэрлэгийн хүрээнд "Тархинд мод тарья" нөлөөллийн аяныг зохион байгуулсан. Ногоон байгууламжийн мэргэжлийн 9 компанийг хороодод хуваарилан мод тарьж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан. Мод, ногоон байгууламжийн усалгаа, уриалга бүхий хөдөлгөөнт 4 постерыг бэлтгэж, дүүрэг, хороодын цахим хуудсаар сурталчилж ажилласан. Мишээл групп ХХК-тай хамтарч 2024 оны 06 дугаар сарын 08, 09-ний өдөр "Цэцгийн баяр – 2024" арга хэмжээний мандлын цэцэг, тасалгааны цэцэг тарьж, арчлах сургалтыг зохион байгуулсан. | | |
| 4 | Арга хэмжээ: 1.4 Тохижилт, бүтээн байгуулалтын жил, Ойн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт | Батлагдсан төлөвлөгөө, тоо | - | 1 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/68 дугаар захирамжаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, 2024 онд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөг Хан-Уул дүүргийн Засаг даргын Зөвлөлийн 02 дугаар сарын 21-ний хуралд танилцуулж, батлуулсан. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/67 дугаар захирамжаар нийслэлийн | 2024.02.21 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавьж ажиллах, тайлагнах<br>2024.01 – 2024.12 | | | | зорилтот жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулж, нийслэлийн нэгдсэн төлөвлөгөөнд санал тусган батлуулсан. | | |
| | | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | - | 90%-иас багагүй | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяны төлөвлөгөө 95 хувийн гүйцэтгэлтэй, зорилтот жилийн хүрээнд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд 90 хувийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж, тайлан мэдээг Ойн газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн байгаль орчны газарт тус тус хүргүүлсэн. | 2024.05.11<br>2024.10.31 | 100 |
| Зорилт 2. Дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт, ногоон байгууламжийг хөгжүүлэх бодлого боловсруулж төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах | | | | | | | |
| 5. | Арга хэмжээ: 2.1<br>Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд тохижилт, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, тоглоомын талбай, спорт талбайг нэмэгдүүлж, ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээний ажилд хотын стандартын хэм хэмжээ, шаардлагыг хангуулж, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнаж ажиллана.<br>2024.04 – 2024.12 | Шинээр нэмэгдүүлсэн цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгийн тоо | 18<br>(2021-2023 он) | 4 | Улсын төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн он дамжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтаар 5, 24 дүгээр хороонд 2, шинээр нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1, 13, 14 дүгээр хороонд 3, дүүргийн төсвийн хөрөнгөөр 22 дугаар хороонд 1 байршилд, 21 дүгээр хорооны Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэнг засварлаж, шинэчлэх 1, нийт 6 байршилд иргэд амарч салхилах, спортоор хичээллэх боломжтой бичил цэцэрлэгийн тохижилтын ажил хэрэгжиж байна. Үүнд:<br>1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 24 дүгээр хорооны Вива сити хорооллын ард Туул гол дагуу тоглоомын талбай, спорт талбай бүхий цэцэрлэгийн тохижилт, улсын төсвийн хөрөнгөөр 5 дугаар хороонд 41 дүгээр сургуулийн баруун талд хэрэгжиж буй цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил бүрэн хэрэгжиж, ашиглалтад орсон. | 2024.04.15<br>2024.11.29 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. Тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч 1 дүгээр хорооны Эрэл хотхон, 13 дугаар хорооны 4 дүгээр хэсэг, 14 дүгээр хорооны 156-р сургууль, 300-р цэцэрлэгийн гадна талбайд 3 бичил цэцэрлэгийн тохижилтын ажил хэрэгжиж, ашиглалтад орсон.<br>3. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төгс жигүүр ХХК 21 дүгээр хороонд Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 1 хөлбөмбөгийн талбай, хос 3х3 сагсан бөмбөгийн талбай, экстрем талбай шинээр байгуулж, 2 ширхэг 5х5 сагсан бөмбөгийн талбайг засварлаж, шинэчилсэн.<br>4. Хан-Уул дүүргийн 22 дугаар хороонд Туул гол дагуу 5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Гарден сити" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Тус ажлын загвар зураг батлагдах шатанд хэрэгжиж байна. | | |
| | | Шинээр нэмэгдүүлсэн тоглоомын талбай, тохижилтын тоо | 64<br>(2021-2023 он) | 10-аас доошгүй | Тоглоомын талбай, спорт талбай шинээр байгуулах байршлын судалгаа мэдээллийг гаргаж, нийслэл, дүүргийн төсөвт санал өгч, шинээр нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажилласан.<br>Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 3,880.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжсэн 12 төсөл арга хэмжээний хүрээнд 1, 3, 4, 8, 12, 14, 15, 19, 20, 21, 24 дүгээр хорооны 17, нийслэлийн төсвийн 810.0 сая төгрөгийн хөрөнгөөр 1, 8, 13, 14, 15, 17, 25 дугаар хорооны 7, нийт 24 байршилд тоглоомын талбай, спорт талбай ашиглалтад орсон.<br>Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 720.0 сая төгрөгийн | 2024.04.15<br>2024.11.29 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөрөнгөөр 1, 7, 25 дугаар хорооны 3 байршилд тоглоомын талбайн тохижилтын 3 төсөл арга хэмжээ гүйцэтгэлийн шатанд он дамжиж, 2 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. | | |
| | | Ашиглалтад оруулсан спорт талбайн тоо | 22 (2021-2023 он) | 9 спорт талбай шинээр байгуулж, 1 спорт заалыг засварлана. | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн хот тохижилтын газарт спорт талбай байгуулах байршлын судалгааг хүргүүлж, 1, 8, 12, 17, 24, 25 дугаар хорооны 9 байршилд 3x3 сагсан бөмбөгийн талбай, чийрэгжүүлсэн талбай байгуулж, ашиглалтад оруулсан.<br>ДТХО, ДОНХС-ийн 900.0 сая төгрөгийн хөрөнгөөр 4, 12, 14, 15, 20, 24, 25 дугаар хороонд 3x3 сагсан бөмбөгийн 7 талбай, хувийн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 1 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулагдсан.<br>Дүүргийн төсвийн 1,650.0 сая төгрөгийн хөрөнгөөр 15 дугаар хороонд 130 дугаар сургуулийн гадна талбайд шинээр спорт талбай байгуулж, 7, 89 дүгээр сургуулийн спорт талбайн засвар, шинэчлэлт, Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 1 хөлбөмбөгийн талбай, хос 3x3 сагсан бөмбөгийн талбай, экстрем талбай шинээр байгуулж, 2 ширхэг 5x5 сагсан бөмбөгийн талбайг засварлаж, шинэчилсэн.<br>Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайн тохижилтын ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр шинээр 5x5 сагсан бөмбөгийн талбай, талбайн теннис, чийрэгжүүлэлтийн талбай байгуулж, ашиглалтад оруулсан.<br>Дүүргийн төсвийн 585.8 сая төгрөгийн хөрөнгөөр 10, 34, 156 дугаар сургуулийн 3 спорт заалыг засварлуулсан. | 2024.04.15<br>2024.11.29 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Засварлаж, шинэчилсэн талбай, эд хөрөнгийн тоо | 4 байршилд цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, 1 хөшөөг засварлаж шинэчилсэн. | 4-өөс доошгүй | Эвдрэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, тоглоомын талбай, явган хүний зам талбайн судалгаа, тооцооллыг боловсруулж, дүүргийн Засаг даргын 17 захирамжаар 1,184.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд стандарт орчны аюулгүй байдлыг хангаж, засварлаж, шинэчлэх чиглэлээр 117 арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 2024.04.15 2024.11.29 | 100 |
| 6. | Арга хэмжээ: 2.2 Явган хүний зам болон дугуйн зам шинээр нэмэгдүүлэх ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих, шинээр нэмэгдүүлэх, засварлаж, шинэчлэх судалгааг боловсруулах 2024.04 – 2024.12 | Явган хүний замын урт, км | 4.9 (2023 он) | 1.5-аас багагүй | Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирлагын хэлтэстэй хамтарч эвдрэлтэй болон шинээр хэрэгжүүлэх явган хүний замын судалгаа, тооцооллыг боловсруулж, нийслэл, дүүргийн төсөвт тусгуулж, явган хүний замыг нэмэгдүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 3, 15, 9, 16, 23, 24 дүгээр хороонд 7500 м.кв (3.0 км), нийслэлийн төсвийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч 3 дугаар хороо, Ажилчны гудамжны 3750 м.кв (2,5 км) явган хүний замыг засварлаж, шинэчилсэн. Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр 11, 19, 20, 24 дүгээр хороонд 10398 м.кв явган хүний замыг засварлаж шинэчлэх 2 төсөл арга хэмжээ гүйцэтгэлийн шатанд он дамжин хэрэгжих, 2, 5, 6, 17, 19, 20, 23, 24 дүгээр хороонд 3680 м.кв (2.3 км) явган хүний замыг засварлаж, шинэчлэх 2 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/291 дүгээр захирамжийн дагуу 145.4 сая төгрөгийн хөрөнгөөр Номун виллаж хотхон, Могул таун хотхонд шинээр явган хүний зам тавих, 1, 2, 3, 6, 18 дугаар | 2024.04.15 2024.11.29 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хороонд эвдрэлтэй 418 м.кв (278 м) явган хүний замыг нөхөж, засварлах ажлыг зохион байгуулсан. | | |
| | | Дугуйн замын урт, км | - | 0.6-аас доошгүй | Дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 23 дугаар хороонд Наадамчдын замаас Гарден сити 2 хороолол хүртэлх авто зам дагуух 1125 метр явган хүний зам, дугуйн замын тохижилтын ажил дуусаж, ашиглалтад орсон.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй авто замын ажлын хүрээнд 4, 5 дугаар хороонд Наадамчдын замыг Эрчим хүчний гудамжтай холбох зам дагуу 2.8 км, 23 дугаар хороонд Наадамчдын замаас Нүхтийн ам чиглэлийн авто зам дагуу 1.6 км, явган хүний зам засварын ажлын хүрээнд Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 120 мянгатын уулзвараас Орчлон сургууль хүртэл 1.3 км дугуйн зам хийгдсэн. | 2024.04.15<br>2024.11.29 | 100 |
| 7. | Арга хэмжээ: 2.3<br>"Бүх нийтээр мод тарих" үндэсний өдөр арга хэмжээг зохион байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, хяналт тавих | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 2 | 1<br>(намар) | "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг хавар, намар 2 удаа зохион байгуулж, нийт 206419 ширхэг мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Тухайлбал:<br>1. Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр гэр хорооллын бүсэд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хорооны 1650 хашаанд гоёлын болон жимсний 7 төрлийн 16,575, 104 СӨХ, 11 сургууль, цэцэрлэг, 10 хорооны гадна нийт 125 байршилд гоёл чимэглэлийн 7767, аж ахуйн нэгж, байгууллагууд орчиндоо 16,872, нийт 41214 ширхэг мод, бут сөөг, тарьсан. | 2024.05.11<br>2024.10.31 | 100 |
| | | Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ, м.кв | 9.32<br>(2023 оны жилийн эцсийн байдлаар) | 9.5 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2024.04 – 2024.12 | | | | 2. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд арчилгаа, нөхөн тарилт хариуцсан 10 байгууллага 19289 ширхэг мод, бут сөөг тарьсан.<br>3. Тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн 14 дүгээр хорооны Айцын аманд нийслэл, дүүргийн 38 хэлтэс албадын 645 албан хаагч 2022-2024 онд байгуулсан 12.3 га талбайд усалгаа, арчилгаа хийж, нэмэлтээр болон нөхөн тарилтаар 3196, Ногоон хэрэм төслийн талбайд Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын харьяа агентлагууд, төрийн захиргааны төв байгууллагууд 9175, Богдхан уулын дархан цаазат газрын Түргэний ам, Зайсангийн ам, Нүхтийн ам, Энхтайвны ам, Ихтэнгэрийн аманд 136 га талбайд уул уурхайн 5 компани, улсын хөрөнгө оруулалтаар 1 компани ойжуулалтын ажил хийж, 133545 ширхэг, нийт 145916 ширхэг мод, бут, сөөг тарьсан байна. | | |
| | | Арчлалт хамгаалалт хийх талбай, м.кв | - | 289,376 | Хот, нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжсэнээр дүүргийн Засаг даргын 2024 оны А/157, А/269 дүгээр захирамжийн дагуу 295,148 м.кв талбайн арчилгааг мэргэжлийн 10 байгууллагад, нэмэлтээр Эрчим хүчний яамны урд талын зам дагуу 3500 м.кв талбай бүхий ногоон байгууламжийг Цэцэгт ногоон хөндий ХХК-д хариуцуулж, агро технологийн 22 ажилбарын дагуу арчилгааны ажилбарыг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллаж байна.<br>Ногоон байгууламжийн арчилгааны ажлын гүйцэтгэлийн захиалагчийн хяналтыг 2024 оны 06 дугаар сарын 02- | 2024.03.01<br>2024.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдрөөс эхлэн Бид байгаль элч ТББ-д хариуцуулан ажиллаж байна. Арчлалт хамгаалалтын ажлын хүрээнд мод, бут сөөг, зүлэгт талбайн цэвэрлэгээ, усалгааг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэж, 2024 оны 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10 дугаар сарын 2,443.7 сая төгрөгийн гүйцэтгэлийг хянаж, үнэлсэн. Байгууллагуудын 2024 оны 11, 12 дугаар сарын гүйцэтгэлийг 12 дугаар сарын 02, 11-ний өдрүүдэд хянаж, үнэлнэ. | | |
| 8. | Арга хэмжээ: 2.4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Айцын аманд байгуулсан ойжуулалтын талбай, Төгсөгчдийн төглийн арчлалт хамгаалалтыг тогтмол гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллана. 2024.01 – 2024.12 | Арчлалт хамгаалалт хийх талбай, га | 8 | 13.5 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/97 дугаар захирамжаар Айцын ам, Төгсөгчдийн төглийн 13.5 га талбайн арчилгааг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулан гэрээ байгуулж, хяналт тавьж ажилласан. Ногоон хот – Иргэний оролцоо мод тарих аяны хүрээнд нийслэл, дүүргийн төр захиргааны 68 хэлтэс албадын 796 албан хаагчид 2022-2024 онд тарьсан модны усалгаа арчилгааг хийж, шинээр болон нөхөн тарилтаар 3196 мод тарьсан. Намрын мод тарилтын ажлын хүрээнд Төгсөгчдийн төгөлд шинээр 178 улиас тарьж, усалгаа арчилгааг хийсэн. | 2024.05.11<br>2024.10.31 | 100 |
| 9. | Арга хэмжээ: 2.5 Ногоон байгууламжийн судалгаа хийж, газарзүйн мэдээллийн санд суурилсан мэдээллийн сан үүсгэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж, батлуулах, ажлын | Батлуулсан ажлын даалгавар, тоо | - | 1 | Ногоон байгууламжийн судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх зөвлөх үйлчилгээ хийх ажлын даалгаврыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газартай зөвшилцөн боловсруулж, 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр батлуулж, Худалдан авах ажиллагааны албанд актаар хүлээлгэж өгсөн. | 2024.01.29<br>2024.02.16 | 100 |
| | | Ногоон байгууламжийн судалгаа, мэдээллийн сан хийх | 10% | 100% | Ногоон байгууламжийн судалгаа, мэдээллийн сан хийх ажлын гүйцэтгэгчээр "Говийн улиас" ХХК шалгарч, ажлын бэлтгэл үе, хээрийн судалгааны шат хэрэгжин дуусч, агаарын | 2024.01.29<br>2024.11.28 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | явц гүйцэтгэлд хяналт тавих 2024.01 – 2024.12 | ажлын явц, хувь | | | зургийг ашиглан ногоон байгууламжийн хил, заагийг дахин засварлаж, зураглах, ногоон байгууламжийн нэгж талбар тус бүрээр мэдээллийн сан үүсгэх шатанд хэрэгжиж байна. | | |
| 10. | Арга хэмжээ: 2.6 Гоёл чимэглэлийн цэцгийн үрсэлгээг хийх, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд цэцгийн мандал байгуулах ажлыг зохион байгуулж, явц, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах 2024.01 – 2024.10 | Үрслүүлсэн цэцэг, тоо | 267,519 | 300,000-аас багагүй | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд цэцэг тарих ажлын төлөвлөгөө, байршлын судалгаа, төсвийн тооцооллыг боловсруулж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/78 дугаар захирамжаар 191.4 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн. “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-аар 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 30 хүртэл 300,000 гаруй ширхэг нэг наст, гоёл чимэглэлийн цэцгийн үрсэлгээг хийлгэж, талбайн бэлтгэл ажлыг бүрэн хангуулсан. | 2024.02.29 2024.05.30 | 100 |
| | | Мандал байгуулсан талбай, м.кв | 5379,3 м.кв (2023 он) | 3000 м.кв-аас багагүй | Батлагдсан төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилт хариуцсан 10 байгууллагаар нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 48 байршилд 478,730 гаруй цэцэг тариулж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгүүлж, хяналт тавьж ажилласан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд цэцэгт байгууламж хийх байршлын судалгаа, саналыг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлж, 2024 оны 06, 07 дугаар сард 8 байршилд 3 хэмжээст хийцлэл бүхий цэцэгт байгууламж хийж, 154,250 ширхэг цэцэг, 300 м.кв зүлэг тарих ажлыг зохион байгуулж, хамтарч ажилласан. | 2024.05.31 2024.10.28 | 100 |
| 11. | Арга хэмжээ: 2.7 | Зүлэгжүүлсэн талбай, м.кв | 24192.8 м.кв | 15,000 м.кв-аас багагүй | Хан-Уул дүүргийн хэмжээнд тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | 2024.05.31 2024.06.04 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сул шороон хөрсийг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгон тоосжилтыг бууруулах ажлын хүрээнд холбогдох судалгаа, тооцооллыг боловсруулж, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлд хяналт тавих 2024.06 – 2024.08 | | | | судалгаа, тооцооллыг боловсруулж, шинээр 18852 м.кв, нөхөн тарилтаар 12048 м.кв, нийт 31200 м.кв талбайг зүлэгжүүлсэн. Үүнд:<br>1. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/328 дугаар захирамжийн дагуу 15 дугаар хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн гадна, 1 дүгээр хорооны 39 дүгээр байрны хойно, 3 дугаар хороонд Эрчим хүчний яамны зам дагуу 2852 м.кв талбайг зүлэгжүүлсэн.<br>2. Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч 629.0 сая төгрөгийн хөрөнгөөр Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбай, Сурын талбай орчмын 11,000 м.кв талбайг зүлэгжүүлсэн.<br>3. Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 8 дугаар хороонд Нүхтийн зам дагуу 5000 м.кв сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлсэн. | | |
| 12. | Арга хэмжээ: 2.8 Гэр хорооллын айл өрхүүдтэй хамтарч мод, бут тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх судалгаа, тооцооллыг боловсруулж, хэрэгжүүлэх, хяналт тавих 2024.05 – 2024.11 | Шинээр тарьсан мод, бутны тоо | 18,450 ширхэг (2023 онд 6, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны 1895 хашаанд тарьсан) | 15,000 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг зохион байгуулах 2 төлөвлөгөөг батлуулж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тарих мод, бут сөөгийг худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр гэр хорооллын бүсэд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хорооны 1650 хашаанд гоёлын болон жимсний 7 төрлийн 16,575 ширхэг мод, бут сөөгийг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна. | 2024.05.17 2024.10.31 | 100 |
| Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 13. | Арга хэмжээ: 3.1 Төрийн албан хаагчийн ёс зүйг | Үйл ажиллагааны | 100 | 100 | Төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөж, ёс зүйн зөрчилгүй ажилласан. | 2024.01.02 2024.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чандлан мөрдөж ажиллана. 2024.01 – 2024.12 | хэрэгжилт, хувь | | | | | |
| 14. | Арга хэмжээ: 3.2 Албан бичиг хэргийг хөтлөх, байгууллага иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг судалж, түргэн шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана. 2024.01 – 2024.12 | Шийдвэрлэлт, хувь | 100 | 100 | 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нутгийн захиргааны байгууллагуудын цахим системээр ирүүлсэн 35 өргөдөл, гомдол, 151 албан бичгийг бүрэн шийдвэрлэсэн. | 2024.01.02 2024.11.28 | 100 |
| 15. | Арга хэмжээ: 3.3 Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг боловсруулах, зохион байгуулах MNS5140:2011 стандартыг мөрдөх 2024.01 – 2024.12 | Шийдвэрлэлт, хувь | 100 | 100 | Албан тушаалын болон хэлтсийн чиг үүргийн хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 23 захирамж, 1 тушаал, 12 ажлын даалгавар, 25 гэрээ, 83 албан бичгийн төслийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. | 2024.01.02 2024.11.28 | 100 |
| 16. | Арга хэмжээ: 3.4 Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн хэрэг бүрдүүлэх, албан хэрэг хөтлөгдөх хугацаа дуусмагц, зохих зааврын дагуу цэгцэлж, бүрэн бүрдэлтэйгээр баримт бичиг хүлээн | Шийдвэрлэлт, хувь | 100 | 100 | Хэлтэст 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан тушаалын чиг үүргийн хүрээнд архивын 5 хадгаламжийн нэгжийн 761 хуудас бүхий баримтыг бүрдүүлж, хуулийн хугацаанд архивт шилжүүлсэн. | 2024.01.02 2024.03.16 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авах хуваарийн дагуу байгууллагын архивт шилжүүлэх<br>2024.01 – 2024.12 | | | | | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ | | | |
| 17 | Арга хэмжээ 1. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд ажиллана.<br>2024.01 – 2024.12 | Хэрэгжилт, хувь | 100% (2023 оны жилийн эцэст 32 үнэлгээний хороонд гишүүнээр ажиллаж, 3 үнэлгээний хороог ахалсан) | 100% | 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах 32 үнэлгээний хороонд гишүүнээр ажиллаж, 7 үнэлгээний хороог ахалж ажилласан. | 2024.01.02<br>2024.11.28 | 100 |
| 18 | Арга хэмжээ 2. Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллах<br>2024.01 – 2024.12 | Гүйцэтгэлийн хувь | 3 удаагийн хуралд оролцсон. | 100% | Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/97 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүнээр томилогдож, тайлант хугацаанд 5 удаагийн хурлаар 11 албан хаагчид холбогдох гомдол мэдээллийг хэлэлцсэн. Үүнээс ёсзүйн зөрчил тогтоогдсон 3 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэж, 5 албан хаагчид зөвлөмж хүргүүлсэн. | 2024.01.02<br>2024.11.28 | 100 |
| 19 | Арга хэмжээ 3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хариуцаж байсан зарим чиг үүргийг дүүрэгт шилжүүлэхтэй холбогдуулан удирдлага, зохион байгуулалтаар хангах | Хэрэгжилт хувь | Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/110 дугаар тушаалаар дэд ажлын хэсэг байгуулагдсан. | 100% | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1461 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/293 дугаар тушаал, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/674 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/110 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн нарийн бичгийн үүргийг гүйцэтгэж ажилласан. | 2023.12.27<br>2024.01.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын хэсгийн нарийн бичгийн үүргийг гүйцэтгэх | | | | Тайлант хугацаанд үүссэн баримт бичгүүдийн бүрдлээр 1 хадгаламжийн нэгжийн 35 хуудас баримтыг дүүргийн архивт шилжүүлсэн. | | |
| 20 | Арга хэмжээ 4. Эко – Эрүүл дүүрэг үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх ажлуудыг танилцуулах, санал авах уулзалтыг зохион байгуулах, оролцоог хангах | Хэрэгжилт, хувь | - | 100% | “Эко – Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх ажлуудыг танилцуулах, санал авах уулзалтыг зохион байгуулж, хэлтсийн чиг үүргийн хүрээнд хог тээвэр, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, сууц өмчлөгчдийн холбоод, инженер хангамжийн байгууллагуудын 600 гаруй хүнийг оролцуулсан. | 2024.02.06<br>2024.04.17 | 100 |
| ХОЁРДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ | | | | | | | |
| 21 | Арга хэмжээ 5. Хот нийтийн чиг үүрэг дүүрэгт шилжсэнтэй холбогдуулан байгууллагуудтай гэрээ байгуулах, ногоон байгууламжийн арчилгааны ажлыг эхлүүлэх | Хэрэгжилт, хувь | Чиг үүргийг хүлээлцэж, акт үйлдсэн. | 100% | “Чиг үүрэг шилжүүлэх тухай” нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1461 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/293 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар 19-ний өдрийн 01/1398 дугаартай албан бичиг, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн шуурхай зөвлөгөөний үүрэг даалгавар, Улаанбаатар хотын Захирагчийн албанаас 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/441 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэл, УБЗАА, гүйцэтгэгч байгууллагууд хооронд 2023 онд байгуулсан ажлын гэрээг тус тус үндэслэн дүүргийн Засаг даргын 2024 оны А/157 дугаар захирамжийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр мэргэжлийн 9 байгууллагатай гэрээ байгуулж, нийтийн эзэмшлийн гудамж талбайн 295,148 м.кв талбайн (шилмүүст мод 5042 ширхэг, навчит мод 6933 ширхэг, бут сөөг 12570, торхтой мод 60 ширхэг, ургамлан хашлага 19237 урт метр) ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын ажлыг хариуцуулан, хяналт тавьж ажиллаж байна. | 2024.03.01<br>2024.06.04 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | Арга хэмжээ 6. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хэрэгжүүлэх бичил цэцэрлэг, 3х3 сагсан бөмбөгийн талбай, явган хүний замын засвар шинэчлэлтийн ажлын талбайн судалгаа хүргүүлэх, зөвшилцөх | Бичил цэцэрлэг тохижилтын тоо | 12, 14 дүгээр хорооны 3 байршилд бичил цэцэрлэг байгуулсан. | 1, 13, 14 дүгээр хорооны 3 байршил | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, тохижилтын ажлын албанд бичил цэцэрлэг, 3х3 сагсан бөмбөгийн талбай, явган хүний замын засвар шинэчлэлт хийх байршлын саналыг хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр байршлууд дээр ажиллаж, зөвшилцсөн.<br>Тус ажлын үр дүнд 1, 13, 14 дүгээр хороонд 3 бичил цэцэрлэг, 8, 17, 25 дугаар хороонд 3 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай шинээр байгуулагдаж, 3 дугаар хорооны Ажилчны гудамжинд 3750 м.кв явган хүний замыг өргөтгөж, шинэчлүүлсэн. | 100 | 2024.11.29 |
| ГУРАВДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ | | | | | | | |
| 23 | Арга хэмжээ 7. Үндэсний их баяр наадмын бэлтгэл хангах, баярын өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн цэвэрлэгээ үйлчилгээний байгууллагуудыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт, хувь | - | 100 | Үндэсний их баяр наадмын бэлтгэл хангах ажлын хүрээнд дүүргийн Менежерээс өгсөн чиглэлийн дагуу Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайн тохижилт, ногоон байгууламж, гадна болон дотор орчны угаалга, цэвэрлэгээ үйлчилгээг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажилласан.<br>Баяр наадмын өдрүүдэд буюу 2024 оны 07 дугаар сарын 10-наас 13-ны өдрийг дуустал Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцаж буй 7 байгууллагыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажилласан. | 100 | 2024.06.01<br>2024.07.14 |
| 24 | Арга хэмжээ 8. Үерийн усны эрсдэлээс сэргийлэх, голын далан хүчитгэх ажлыг зохион байгуулах | Хэрэгжилт, хувь | - | 100 | Үерийн усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн Менежерээс өгсөн чиглэлийн дагуу 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Баатарсүрэн, Авто зам, дэд бүтэц хариуцсан инженер Б.Нарандулам нар 12 дугаар хорооны Сонгино 4 дүгээр хэсэгт Туул гол сэтэрч, айл өрх, аж ахуйн нэгжүүд усанд автах эрсдэл үүссэн байршилд ажиллаж, гол дагуу шороон далан босгож, | 100 | 2024.08.05 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүчитгэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажилласан.<br>Тус ажлын хүрээнд 1.5 – 2.0 метрийн өндөртэй 90 метр шороон даланг босгож, хүчитгэх арга хэмжээ авч, үерийн эрсдэлийг бууруулсан. | | |
| 25 | Арга хэмжээ 9.<br>Нийслэлийн удирдах ажилтнуудын 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 16 дугаар шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, хороодод ажиллаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, үр дүнг танилцуулах | Хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаварын хүрээнд дүүргийн Засаг даргатай 2024 оны 08 дугаар сарын 03-наас 09 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл хугацаанд 3, 4, 5, 6, 7, 8, 11, 17, 18, 15, 19, 20 дугаар хороодоор ажиллаж, авто зам, тоглоомын талбай, явган хүний зам талбайн засвар, шинэчлэлт, газар чөлөөлөлт, хог хаягдлын чиглэлээр 46 арга хэмжээг холбогдох нэгж, албан хаагчидтай хамтарч хэрэгжүүлсэн.<br>Ажлын явц, гүйцэтгэлийг Засаг дарга нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхайд 2 удаа танилцуулсан. | 100 | 2024.08.03<br>2024.09.06 |
| 26 | Арга хэмжээ 10.<br>Нийслэл, дүүргийн сонгуулийн 29-24-3 дугаар хэсгийн хороог ахалж ажиллах | Хэрэгжилт, хувь | - | 100 | Хан-Уул дүүргийн Сонгуулийн хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор нийслэл, дүүргийн сонгуулийн 29 дүгээр тойргийн 24-3 дугаар хэсгийн ахлах зохион байгуулагчаар томилогдож ажилласан.<br>Хэсгийн хорооны 3 хадгаламжийн нэгжийн 483 хуудас баримтыг бүрдүүлж, 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Сонгуулийн хороонд хүлээлгэж өгсөн. | 100 | 2024.09.16<br>2024.10.26 |
| 27 | Арга хэмжээ 11.<br>Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй авто зам, гүүрийн барилга угсралтын ажлын трасст өртсөн ногоон байгууламжийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих | Хэрэгжилт, хувь | - | 100 | Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 2 авто зам, гүүрийн барилга угсралтын трасст өртсөн ногоон байгууламжийн талбайн хэмжилт, тооллогыг хийж, акт үйлдэж, мэргэжлийн байгууллагаар стандартын дагуу шилжүүлүүлж, хяналт тавьж ажилласан. Үүнд:<br>- Наадамчдын замыг Эрчим хүчний гудамжтай холбох авто зам, гүүрийн трасст өртсөн 15 нарс, 75 метр ургамлан хашлага, 48 бут сөөг; | 100 | 2024.09.20<br>2024.10.31 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Нисэхийн аюулгүйн тойргийг олон түвшинт уулзвар болгох ажлын трасст ертсөн 101 ширхэг нарс, 49 ширхэг улиас, 136 бут сөөг, 135 урт метр ургамлан хашлага; | | |
| ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ | | | | | | | |
| 28 | Арга хэмжээ 12. Арчилгаатай талбайгаас бусад нийтийн эзэмшлийн гудамж, талбайн мод, бут сөөгийг хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих; | Хэрэгжилт, хувь | - | 100 | Нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууц хорооллын дунд явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй, хэлбэржүүлэлт, цэвэрлэгээний огтлол хийх шаардлагатай модны судалгааг гаргаж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/635 дугаар захирамжаар 18.9 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж, Үр үрслэх ХХК-иар гүйцэтгүүлсэн.<br>Тус ажлын хүрээнд 153 ширхэг улиас, 215 ширхэг хайлаас, 3 ширхэг монос нийт 373 ширхэг модны гувар сэжим цэвэрлэх, мөчрийн цөөлөлт хийж, 12500 м.кв талбайд хэлбэржүүлэлтийн дараах цэвэрлэгээ, шарилж устгал хийж, 52 тн хог хаягдыг ачиж тээвэрлэсэн.<br>Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ургалт зогссон мод, бут сөөгийг 2024 оны 4, 5 дугаар сард авах ажлыг зохион байгуулна. | 2024.10.08<br>2024.10.31 | 100 |
| 29 | Арга хэмжээ 13. Дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах, хурлаар батлуулах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт, хувь | - | 100 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/682 дугаар захирамжаар дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж байна.<br>Тус ажлын хүрээнд 1 удаагийн нэгдсэн хуралдаанд оролцож, үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлтэй танилцаж, 18 зорилтод өөрчлөлт оруулж, 1 зорилтыг шинээр нэмэх санал оруулсан. | 2024.10.30 | 100 |
| 30 | Арга хэмжээ 14. Автобусны 2 дулаан буудлыг цахилгаан | Хэрэгжилт, хувь | - | 100 | Дүүргийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу 1, 15 дугаар хорооны автобусны буудалд байрлуулсан дулаан байгууламжийг цахилгаан эрчим хүчээр хангах асуудлаар 2 | 2024.11.01<br>2024.11.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрчим хүчээр хангах арга хэмжээ авах | | | | компанитай зөвшилцөж, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн захирамжаар 3.7 сая төгрөгийн зардлыг шийдвэрлүүлсэн. Тус ажлыг "Нийтлэг үйлчилгээний алба" ОНӨААТҮГ 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр гүйцэтгэсэн. | | |
| 31 | Арга хэмжээ 15. Цас орсон үед шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт тавих | Гүйцэтгэл, хувь | - | 100 | Дүүргийн Менежерийн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн баталсан хуваарийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Гранд зевс ХХК, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын хариуцан ажиллаж буй зам талбайн халтиргаа гулгааг арилгах, давс бодис цацах ажил болон Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын авто баазад ажиллаж, машин техникийн бэлэн байдлыг хангуулж, шуурхай арга хэмжээ авч ажилласан. | 2024.11.26 | |
| 32 | Арга хэмжээ 16. Гэрэлтүүлэг, камержуулалт хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр хавсран гүйцэтгэх | Хэрэгжилт, хувь | - | 100 | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Б/193 дугаар тушаалаар Гэрэлтүүлэг, камержуулалт хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр хавсран гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд гэрэлтүүлгийн урсгал, засварын 3 компани, камерын засварын 1 байгууллагын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, хэрэгжилтийг удирдлагуудад тайлагнаж ажиллаж байна. Байгууллагуудын 2024 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлийг 12 дугаар сарын 02, 12 дугаар сарын гүйцэтгэлийг 12 дугаар сарын 11-нд авч, үнэлнэ. | 2024.11.01<br>2024.11.29 | |
| 33 | Арга хэмжээ 17. Сүлд мод засах, гэрлэн чимэглэл хийх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах, нарийн бичгийн үүрэг гүйцэтгэх | Гүйцэтгэл, хувь | - | 100 | Дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/713 дугаар захирамжаар сүлд мод засах, гэрлэн чимэглэл хийх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, нарийн бичгийн үүргийг гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар ажлын хэсгийн 2 | 2024.11.22<br>2024.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удаагийн хурлыг зохион байгуулж, Засаг дарга ажлын явцыг нийслэлийн ажлын хэсгийн хуралд танилцуулах бэлтгэл хангасан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 34 | Арга хэмжээ 1.<br>Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнийг дагалдан гарсан дүрэм, журмын сургалтад хамрагдах<br>2024.01 – 2024.12 | Хамрагдсан сургалтын тоо | - | 1 | Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хэрэгжүүлэх тухай танилцуулга, цахим сургалтад хамрагдсан.<br>Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал сэдэвт илтгэл арга хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр оролцсон. | 2024.04.25<br>2024.11.08 | 100 |
| 35 | Арга хэмжээ 2.<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалтад хамрагдах<br>2024.01 – 2024.12 | Хамрагдсан сургалтын тоо | - | 1 | Авлигатай тэмцэх газраас 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад зохион байгуулсан “2023 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргах тухай” сэдэвт цахим сургалтад хамрагдсан. | 2024.01.25 | 100 |
| 36 | Арга хэмжээ 3.<br>Ажил үүргийн чиг үүрэгтэй холбоотой нийслэл, дүүрэг болон бусад газруудаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх<br>2024.01 – 2024.12 | Хамрагдсан сургалтын тоо | 10 | 4-ээс багагүй | - “Улаанбаатар бүсчилсэн хөгжил” сэдэвт 2 удаагийн хэлэлцүүлэг;<br>- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Ойн газраас зохион байгуулсан “Ой 9+” хэлэлцүүлэг;<br>- Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос 2024 оны I улирлын үйл ажиллагааны тайлан болон Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнээс урьдчилан | 2024.03.05<br>2024.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэргийлэх талаар мэдээлэл танилцуулах хэлэлцүүлэг;<br>- Нийслэлээс зохион байгуулсан "Цахим хөгжлийг дэмжих хууль, тоон гарын үсгийн хэрэглээ, цахим ур чадварын талаар" сургалт<br>- "Стресс, түүнийг хэрхэн таних, стрессээс үүдэлтэй үр дагаврууд" сургалт<br>- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын дунд 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан танин мэдэхүйн хөгжөөнт "UB QUIZ-385" тэмцээнд, Засаг даргын Тамгын газрын багаар оролцсон.<br>- Улаанбаатар марафон 2024 олон улсын гүйлтэд 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр оролцсон.<br>- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай журам, албан бичгийн стандарт, идок системийн хөгжүүлэл сэдэвт сургалт, 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр<br>- Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал сэдэвт илтгэл арга хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр; | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.БААТАРСҮРЭН / ................................ /

2024.11.29

127

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Үндэсний их баяр наадмын бэлтгэл хангах, баярын өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн цэвэрлэгээ үйлчилгээний байгууллагуудыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах | Хан-Уул дүүргийн Онцгой комисс, Менежер | Хэрэгжилт, хувь | - | 100% | 06 | 07 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

.................................... Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.06.15
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

.................................... Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.06.15
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Үерийн усны эрсдэлээс сэргийлэх, голын далан хүчитгэх ажлыг зохион байгуулах | Хан-Уул дүүргийн Онцгой комисс, Менежер | Хэрэгжилт, хувь | - | 100% | 08 | 09 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

.................................. Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.08.05
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

.................................. Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.08.05
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. Нийслэлийн удирдах ажилтнуудын 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 16 дугаар шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, хороодод ажиллаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, үр дүнг танилцуулах | Хан-Уул дүүргийн Засаг дарга | Хэрэгжилт, хувь | - | 100% | 08 | 10 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

.................................... Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.08.05
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

.................................... Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.08.05
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10. Нийслэл, дүүргийн сонгуулийн 29-24-3 дугаар хэсгийн хороог ахалж ажиллах | Хан-Уул дүүргийн Сонгуулийн хорооны дарга | Хэрэгжилт, хувь | - | 100% | 09 | 10 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

.................................... Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.09.16
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

....................................Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.09.16
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 11. Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй авто зам, гүүрийн барилга угсралтын ажлын трасст өртсөн ногоон байгууламжийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих | Хан-Уул дүүргийн Менежер | Хэрэгжилт, хувь | - | 100% | 09 | 10 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

.................................. Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.09.20
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

.................................. Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.09.20
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 12. Арчилгаатай талбайгаас бусад нийтийн эзэмшлийн гудамж, талбайн мод, бут сөөгийг хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих; | Хан-Уул дүүргийн Менежер | Хэрэгжилт, хувь | - | 100 | 10 | 11 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

.................................... Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.10.08
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

.................................... Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.10.08
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 13. Дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах, хурлаар батлуулах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хан-Уул дүүргийн Засаг дарга | Хэрэгжилт, хувь | - | 100 | 10 | 12 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

.................................... Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.10.30
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

.................................... Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.10.30
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 14. Автобусны 2 дулаан буудлыг цахилгаан эрчим хүчээр хангах арга хэмжээ авах | Хан-Уул дүүргийн Засаг дарга | Хэрэгжилт, хувь | - | 100 | 11 | 11 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

.................................... Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.11.01
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

.................................... Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.11.01
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 15. Цас орсон үед шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт тавих | Хан-Уул дүүргийн Менежер | Гүйцэтгэл, хувь | - | 100% | 11 | 12 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

................................ Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.11.15
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

................................ Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.11.15
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 16. Гэрэлтүүлэг, камержуулалт хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр хавсран гүйцэтгэх | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга | Хэрэгжилт, хувь | - | 100% | 11 | - |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
*(Албан тушаал)*

................................ Э.БААТАРСҮРЭН
*(Нэр, гарын үсэг)*

2024.11.15
*(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
*(Албан тушаал)*

................................ Г.ТУЯАЦЭЦЭГ
*(Нэр, гарын үсэг)*

2024.11.15
*(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 17. Сүлд мод засах, гэрлэн чимэглэл хийх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах, нарийн бичгийн үүрэг гүйцэтгэх | Хан-Уул дүүргийн Менежер | Гүйцэтгэл, хувь | - | 100% | 11 | 12 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ........................ Э.БААТАРСҮРЭН 2024.11.22
*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА ........................ Г.ТУЯАЦЭЦЭГ 2024.11.22
*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.БААТАРСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| Стратегийн төлөвлөгөөний зорилго 1. "Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ. | | | | | |
| Зорилт 1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангах, тайлагнах | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 1.2 | 50 | 5 | 55 | |
| 3. | Арга хэмжээ 1.3 | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 1.4 | 60 | 10 | 70 | |
| Зорилт 2. Дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт, ногоон байгууламжийг хөгжүүлэх бодлого боловсруулж төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах | | | | | |
| 5. | Арга хэмжээ 2.1 | 60 | 10 | 70 | |
| 6. | Арга хэмжээ 2.2 | 60 | 10 | 70 | |
| 7. | Арга хэмжээ 2.3 | 60 | 10 | 70 | |
| 8. | Арга хэмжээ 2.4 | 60 | 10 | 70 | |
| 9. | Арга хэмжээ 2.5 | 50 | 5 | 55 | |
| 10. | Арга хэмжээ 2.6 | 60 | 10 | 70 | |
| 11. | Арга хэмжээ 2.7 | 60 | 10 | 70 | |
| 12. | Арга хэмжээ 2.8 | 60 | 10 | 70 | |
| Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | | | | | |
| 13. | Арга хэмжээ 3.1 | 60 | 10 | 70 | |
| 14. | Арга хэмжээ 3.2 | 60 | 10 | 70 | |
| 15. | Арга хэмжээ 3.3 | 60 | 10 | 70 | |
| 16. | Арга хэмжээ 3.4 | 60 | 10 | 70 | |
| Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт | | | | | |
| 17. | Арга хэмжээ 1. | 60 | 10 | 70 | |
| 18. | Арга хэмжээ 2. | 60 | 10 | 70 | |
| 19. | Арга хэмжээ 3. | 60 | 10 | 70 | |
| 20. | Арга хэмжээ 4. | 60 | 10 | 70 | |
| 21. | Арга хэмжээ 5. | 60 | 10 | 70 | |
| 22. | Арга хэмжээ 6. | 60 | 10 | 70 | |
| 23. | Арга хэмжээ 7. | 60 | 10 | 70 | |
| 24. | Арга хэмжээ 8. | 60 | 10 | 70 | |
| 25. | Арга хэмжээ 9. | 60 | 10 | 70 | |
| 26. | Арга хэмжээ 10. | 60 | 10 | 70 | |
| 27. | Арга хэмжээ 11. | 60 | 10 | 70 | |
| 28. | Арга хэмжээ 12. | 60 | 10 | 70 | |
| 29. | Арга хэмжээ 13. | 60 | 10 | 70 | |
| 30. | Арга хэмжээ 14. | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 31. | Арга хэмжээ 15. | 60 | 10 | 70 | |
| 32. | Арга хэмжээ 16. | 60 | 10 | 70 | |
| 33. | Арга хэмжээ 17. | 60 | 10 | 70 | |
| | Дундаж оноо | 59,3 | 9,6 | 68,9 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 34 | Арга хэмжээ 1. | | 15 | |
| 35 | Арга хэмжээ 2. | | 15 | |
| 36 | Арга хэмжээ 3. | | 15 | |
| | Дундаж оноо | | 15 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| | **Дундаж оноо** | 7 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо** | |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 68,9 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| | Нийт оноо | 98,9 |

***Үнэлгээ өгсөн:***
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

***Нэгжийн дарга***

Г.Туяацэцэг
2024.11.29 .........
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***
Ногоон байгууламжийн гүйцэтгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Э.Баатарсүрэн
2024.11.29
*(огноо)*

***Үнэлгээг хянасан:***
*Үнэлгээний багийг төлөөлж ажлын хэсгийн дарга:*
Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

Л.Отгонбаяр
2024.12.13
*(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Саранцацрал
2024.12.13
*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч***

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

З.Буянт
2024.12.13
*(огноо)*